# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 22 (355)

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:**

- *Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Үндэсний Их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:**

- *Хууль бусаар алт олборлож байгаа талаар авах зарим арга хэмжээний тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2004 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны зургаадугаар сарын 7 №22 (355)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 263. | Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 516 |
| 264. | Үндэсний Их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 517 |
| 265. | Үндэсний Их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | | 518 |
| 266. | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 518 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 267. | Ховд аймгийн Алтай сумын төвийг нүүлгэн шилжүүлэх тухай | Дугаар 26 | 518 |
| 268. | Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 2/01 дүгээр дүгнэлтийн тухай | Дугаар 27 | 518 |
| 269. | Монгол Улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай | Дугаар 28 | 519 |
| 270. | "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 29 | 519 |


### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 271. | Цэргийн дүрэмт хувцасны зарим загварыг батлах тухай | Дугаар 83 | 524 |
| 272. | Удо Хаазег "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 86 | 525 |


### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 273. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлах тухай | Дугаар 84 | 525 |
| 274. | Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай | Дугаар 85 | 530 |
| 275. | Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан байгуулах тухай | Дугаар 86 | 532 |
| 276. | Хууль бусаар алт олборлож байгаа талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 87 | 534 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэр:

"Монгол Улсын Ерөнхийлөгч чуулганд өөрийн таалалаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлэх, төрийн бодлогын аливаа асуудлаар Улсын Их Хуралд саналаа оруулж, үг хэлж болно."

2/ $14^1$ дүгээр зүйл.

**"$14^1$ дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл, түүний чиг үүрэг**

$14^1$.1. Улсын Их Хурлын даргын дэргэд доор дурдсан бүрэлдэхүүнтэй Зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана:

$14^1$.1.1. Улсын Их Хурлын дэд дарга;
$14^1$.1.2. Байнгын хорооны дарга;
$14^1$.1.3. нам, эвслийн бүлгийн ахлагч.

$14^1$.2. Зөвлөл дараах чиг үүрэгтэй:

$14^1$.2.1. Улсын Их Хурлын чуулганаар долоо хоногийн хэлэлцэх асуудлыг зөвшилцөх;

$14^1$.2.2. шаардлагатай тохиолдолд нам, эвслийн бүлгийн хуралдах хуваарьт өдрөөс бусад ажлын өдөр хуралдах Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны хуваарийг тогтоох;

$14^1$.2.3.Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдааны хуваарь тогтоох;

$14^1$.2.4. Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудал.

$14^1$.3. Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга тогтооно."

3/ 16 дугаар зүйлийн 3,4,5 дахь хэсэг:

"16.3. Байнгын болон дэд хороо дүрэмтэй байна. Байнгын хорооны үлгэрчилсэн дүрмийг Улсын Их Хурал батална.

16.4. Улсын Их Хурлын Тамгын газрын төсөвт Байнгын хорооны ажлын албаны үйл ажиллагааны зардлыг тусгайлан тусгана.

16.5. Байнгын хороо тогтоосон журмаар үйлдсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ."

4/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"15.1.4. хуралдааны явцад ёс зүйн зөрчил гаргасан гэж үзвэл тухайн гишүүний талаар Ёс зүйн дэд хороонд санал тавих."

5/ $15^1$ дүгээр зүйл. Хуралдааны дэг сахиулагч

"$15^1$.1. Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны танхимд хуралдааныг тасралтгүй явуулах, хэвийн ажиллагааг хангах үүднээс хуралдааны дэг сахиулагч ажиллана.

$15^1$.2. Хуралдааны дэг сахиулагч нь албаны хувцас, тусгай таних тэмдэгтэй байна. Албаны хувцас, тусгай таних тэмдгийн загварыг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

$15^1$.3.Хуралдааны дэг сахиулагч нь дараах эрх, үүрэгтэй байна:

$15^1$.3.1.хуралдааны танхимд журам сахиулах;
$15^1$.3.2.хуралдаан даргалагчийн зүгээс дэг сахиулах талаар өгсөн үүргийг хэрэгжүүлэх;

$15^1$.3.3. гишүүнд энэ хуулийн 15.1.3-т заасан арга хэмжээ авах тохиолдолд шаардлагатай бол биед нь гэмтэл учруулахгүйгээр хуралдааны танхимаас гаргах."

6/ 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"34.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Улсын Их Хурлын ерөнхий менежерийн хувьд холбогдох Байнгын хорооны даргын саналыг харгалзан Байнгын хорооны ажлын албаны ажилтанг томилж, чөлөөлнө."

7/ 36 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

"36.2. Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно."

36.3. Тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг тавьсан хугацаатай давхацвал хоригийг хэрхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, бусад шийдвэр, бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно."

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14.6-ын "Улсын Их Хурлын даргад" гэсний дараа "урьдчилан"; мөн хуулийн 16.1, 17.1.1-17.1.3, 17.1.6, 17.1.7, 17.1.9, 18.3, 19.3, 19.5, 22.1.1, 32.1.15-ын "дүгнэлт" гэсний өмнө "санал"; 26.2.2-ын "чуулганаар" гэсний өмнө "нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын саналыг харгалзан" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараахь зүйлийн хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"8.5. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааныг чуулганы хугацаанд долоо хоног бүрийн Пүрэв гаригт, Баасан гаригийн үдээс хойш хуралдуулахаар зохион байгуулна. Шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хуралдах хуваарьт өдрөөс бусад ажлын өдөр зохион байгуулж болно."

2/ 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

"14.7. Улсын төсөв, дараа жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон улс орны нийгэм, эдийн засгийн онцгой чухал асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх явцад Байнгын хороод санал, дүгнэлтээ бэлтгэхэд тодорхой хугацаа шаардагдах, сонгогчдоос санал авах, түүнчлэн тухайн үеийн нөхцөл байдлын улмаас зайлшгүй шаардлага гарвал Байнгын хорооны болон нам, эвслийн бүлгийн саналыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг 7-14 хоногийн хугацаагаар түр завсарлуулж болно."

3/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"15.1.3. хуралдааны дэгийг удаа дараа зөрчсөн, хуралдааныг хэвийн явуулахад саад болж байгаа тохиолдолд урьдчилан сануулахгүйгээр чуулганы хуралдаанаас гаргана."

4/ 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"28.3. Байнгын хорооны дарга хорооныхоо өдөр тутмын ажлыг удирдаж, хуралдааныг даргална. Байнгын хорооны дарга 7-гоос дээш хоногийн хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх, дотоод, гадаадад томилолтоор ажиллах зэргээр эзгүй байх хугацаанд түүний саналыг харгалзан Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон нэг гишүүн үүргийг нь түр орлон гүйцэтгэнэ."

5/ 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэр:

"Улсын Их Хурлын Тамгын газрын ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө."

**4 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26.2.1-ийн "ээлжит болон ээлжит бус" гэснийг "ээлжит, ээлжит бус болон хүндэтгэлийн" гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.1.8-ыг хассугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2004 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр** | **Улаанбаатар хот**

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 16.3-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө улсын баяр наадамд 6 давсан бөхөд улсын харцага, 8 давсан бөхөд улсын гарьд цолыг тус тус олгоно.

**2 дугаар зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан улс, аймаг, сумын цолыг нэхэн олгохгүй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараахь агуулгатай 5 дахь заалт нэмсүгэй.

"5/ Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 11.3-т заасан үндэслэл бий болсон бол."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

### Ховд аймгийн Алтай сумын төвийг нүүлгэн шилжүүлэх тухай

Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Алтай сумын төвийг "Боомын ам"-нд нүүлгэн шилжүүлсүгэй.

2. Ховд аймгийн Алтай сумын төвийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

### Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 2/01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 15.1.5, 15.1.6-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана." гэсэн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн", Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ." гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 2/01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 12, 14, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 2/01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр** | **Дугаар 28** | **Улаанбаатар хот**

### Монгол Улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг дор дурдсан үзүүлэлт, хувь хэмжээгээр зөвшөөрсүгэй:

1. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн доод хэмжээ, хувь 6.0

2. Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлтийн дээд хэмжээ, хувь 5.0

/ДНБ-д эзлэх хувиар/

3. Төсвийн нийт орлогын доод хэмжээ 41.4

4. Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 46.0

5. Төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээ 7.1

6. Төсвийн алдагдлын дээд хэмжээ -4.6

7. Хөрөнгө оруулалтын зардлын дээд хэмжээ 5.9

8. Төсөвт байгууллагад ажиллагчдын цалингийн нийт сангийн дээд хэмжээ 8.2

Хоёр. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын 2005 оны төсвийн төслийг боловсруулахдаа эдгээр үзүүлэлтүүдийг баримтлахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Н.Баяртсайхан/, Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/ -нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр** | **Дугаар 29** | **Улаанбаатар хот**

### "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг."Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д дараахь заалт нэмсүгэй:

1/ 1.3.5 дахь заалт:

"1.3.5.үг хэлэх, тайлбар хийхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг үг хэлж байхад яриаг таслах, өмнөөс нь үг хэлэх, санал өгөх, доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, хувийн шинж чанартай үндэслэл гаргах, өөрийн саналыг дэмжүүлэх, эсхүл бусдын саналыг няцаах зорилгоор тэднийг албадах, шахалт үзүүлэхийг хориглоно."

2/ 1.12 дахь заалтын 3 дахь өгүүлбэр:

"Тайлбар өгөөгүй бол хуралдаан тасалсанд тооцно."

3/ Арван нэг[1]:

"**Арван нэг[1]. Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг Ерөнхийлөгч томилохдоо Улсын Их Хуралтай зөвшилцөх**

11[1].1. Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна.

11[1].2. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн санал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлттэй танилцаад Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох асуудлаар ил санал хураалт явуулж, дүнг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ."

4/ Арван нэг[2]:

"**Арван нэг[2]. Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын албан тушаалтныг томилох, чөлөөлөх**

11[2].1. Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын бүрэлдэхүүн, удирдах албан тушаалтныг эрх бүхий этгээдээс санал болгосны дагуу Улсын Их Хурлаас томилох, чөлөөлөх асуудлыг холбогдох Байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна. Улсын Их Хурлын гишүүд тухайн албан тушаалд нэр дэвшигчид асуулт тавьж, хариулт авч болно.

11[2].2. Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, санал дүгнэлт гаргасны дараа тухайн албан тушаалд нэр дэвшигчийг томилох, албан

тушаалтныг чөлөөлөх тухай асуудлаар тус бүрт нь ил санал хураалт явуулна. Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын бүрэлдэхүүнийг томилохдоо хүн тус бүрээр ил санал хураалт явуулна.

Дээрх асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална."

5/ Арван хоёр[1]:

**"Арван хоёр[1]. Засгийн газрын тайланг хэлэлцэх**

12[1].1.Засгийн газар нь үйл ажиллагааныхаа тайланг хаврын чуулганы эхэнд Улсын Их Хуралд ирүүлнэ.

12[1].2.Засгийн газрын үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд танилцуулах бөгөөд Засгийн газрын гишүүд байлцана. Тайлантай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч болно.

12[1].3.Байгаль орчны төлөв байдлын тайланг хэлэлцэхдээ энэ дэгийн 12[2].2, 12[2].3 дахь заалтыг баримтална."

6/ Арван хоёр[2]:

**"Арван хоёр[2]. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын тайланг хэлэлцэх**

12[2].1.Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагууд нь үйл ажиллагааныхаа тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан гишүүдийн тоогоор Улсын Их Хуралд ирүүлнэ.

12[2].2.Зохих Байнгын хороо хуралдаанаараа холбогдох тайланг урьдчилан хэлэлцэх бөгөөд хэлэлцүүлэгтэй холбогдуулан асуулт, хариулт явуулж, гишүүд санал, дүгнэлт гаргаж болно. Шаардлагатай гэж үзвэл тухайн Байнгын хороо уг асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна.

12[2].3.Тайланг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдийн саналаар уг байгууллага, холбогдох албан тушаалтанд ажил сайжруулах, тодорхой асуудалд анхаарах талаар үүрэг даалгавар өгч Байнгын хороонoос, эсхүл Улсын Их Хурлаас тогтоол гаргаж болно.

7/ Арван хоёр[3]:

**"Арван хоёр[3]. Улсын ерөнхий прокурорын мэдээлэл сонсох**

12[3].1.Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи Улсын ерөнхий прокурорын мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсоно.

12[3].2.Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно.

8/ Арван хоёр[4]

**"Арван хоёр[4]. Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл сонсох**

12[4].1.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд илтгэнэ.

12[4].2.Илтгэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно."

9/ Арван хоёр[5]

**"Арван хоёр[5]. Улсын Их Хурлын Тамгын газрын тайланг хэлэлцэх**

12[5].1.Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулна.

12[5].2.Тайлантай холбогдуулан Байнгын хорооны гишүүд асуулт асууж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно.

10/ Арван хоёр[6]

**"Арван хоёр[6]. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаар Улсын Их Хурал олон нийтэд мэдээлэх**

12[6].1.Засгийн газар Улсын Их Хурлын сонгуулийг зарлахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаархи мэдээллийг Улсын Их Хуралд ирүүлнэ.

12[6].2.Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаархи мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд танилцуулна. Уг мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч болно.

12[6].3.Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаархи мэдээлэлтэй танилцсаны дараа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан улсын эдийн засгийн гол үзүүлэлт, Улсын Их Хурлын сонгууль болох оны жилийн эцсийн санхүүгийн төлөв, санхүүгийн төлөвт тусгагдаагүй боловч Засгийн газрын урьд гаргасан шийдвэрийн улмаас гарч болзошгүй өр төлбөр, нэмэлт зардал, орлогын дутагдлын талаархи төсвийн эрсдэл, төсвийн болон эдийн засгийн төлөвт нөлөөлж болох бусад хүчин зүйлийн талаар Улсын Их Хурлын дарга мэдээлнэ."

11/ Арван гурав[1]

**"Арван гурав[1]. Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын талаар мэдээлэх**

13[1].1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32.1.11-д заасны дагуу Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын талаар холбогдох Байнгын хороонд, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга мэдээлнэ.

13[1].2.Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч болно."

12/ 14.2-ын 5 дахь өгүүлбэр:

"Хэрэв Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт нь тухайн асуудлыг хариуцаж байсан Байнгын хорооны санал, дүгнэлттэй санал нэгдээгүй тохиолдолд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд зохих Байнгын хорооны саналаар эхэлж санал хураалт явуулна."

13/ 15.1.4 дэх заалтын 2 дахь өгүүлбэр:

"Хэрэв Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт нь тухайн асуудлыг хариуцаж байсан зохих Байнгын хорооны санал, дүгнэлттэй нэгдээгүй тохиолдолд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Хууль зүйн байнгын хорооны саналаар эхэлж санал хураана. Энэ санал нь олонхийн санал авч чадаагүй бол зохих Байнгын хорооны санал дэмжигдсэнд тооцно."

14/ 15.2 дахь заалт:

"15.2.Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь хэсэгт заасан асуудлаар Үндсэн хуульд нийцэж байна гэж Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл цэцийн аль нэг гишүүн танилцуулж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсоно. Уг асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахгүй."

15/ 15.3-ын 4 дэх өгүүлбэр:

"Тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байхгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний эзгүйд цэцийн аль нэг гишүүн танилцуулж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсоно. Уг асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахгүй."

16/ 20.5 дахь заалт:

"20.5.Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн дараа жилийн улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тогтоосон төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэхэд доорхи журмыг баримтална:

1/төсвийн хүрээний мэдэгдлийг нам, эвслийн бүлэг, Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Засгийн газрын дунд хугацааны зорилтууд, тухайн жилд Монгол Улсын төсвийн урсгал зардал, орлогын хэмжээ, хөрөнгө оруулалт, нийт болон урсгал тэнцэл, төлөвлөсөн баланс, мөнгөн гүйлгээ зэрэг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтээр тооцоо, танилцуулгыг төсвийн ерөнхийлөн захирагч нэг бүрээр гаргуулан авч хэлэлцэнэ. Шаардлагатай бол ажлын хэсэг байгуулан ажиллуулж Байнгын хорооны санал, дүгнэлт бэлтгэнэ.

**Нэг дэх хэлэлцүүлгээр:** төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагчдыг байлцуулан асуулт хариулт явуулж, санал дүгнэлт гаргана. Төсвийн хүрээний мэдэгдлийн талаар Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, санал, дүгнэлт гаргасны дараа Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.

**Хоёр дахь хэлэлцүүлгээр:** төсвийн хүрээний мэдэгдлийн талаар Улсын Их Хурлын Байнгын хороод, нам, эвслийн бүлэг олонхийн дэмжлэг авсан саналаа нэгтгэн, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд ирүүлнэ. Төсвийн байнгын хороо эдгээр саналыг нэгтгэн, нягтлан үзэж хорооныхоо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг нэгтгэн дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна.

Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлт болон Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг тус тус Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсгоно. Төсвийн байнгын хорооны олонхийн дэмжлэг авсан саналаар санал хураалт явуулж гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.

**Гурав дахь хэлэлцүүлгээр:** Төсвийн байнгын хороо олонхийн дэмжлэг авсан саналыг төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусган танилцуулгын хамт Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна. Төсвийн хүрээний мэдэгдлийг санал хураалт явуулж шийдвэрлэнэ."

17/ Хорин хоёр[1]:

"Хорин хоёр[1]. Нээлттэй сонсох

22[1].1.Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх тодорхой төслийн талаар эрдэмтэд, шинжээчид, мэргэжлийн байгууллагын болон сонирхлын бүлгийн хүмүүсээс санал сонсох, мэдээлэл авах зорилгоор нээлттэй сонсож болно.

22[1].2.Тухайн Байнгын хорооны дарга нээлттэй сонсох төслийн сэдэв, өдөр, цагийг 1 сарын өмнө Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн товлож, нийтэд зарлана.

$22^1$.3.Нээлттэй сонсох үйл ажиллагаанд оролцох хүмүүсээс санал, мэдээллийг урьдчилан авч Байнгын хорооны гишүүдэд 3-аас доошгүй хоногийн өмнө тараасан байна.

$22^1$.4.Байнгын хорооны хуралдаанд асуудлыг нээлттэй сонсох үйл ажиллагаанд оролцогчдод санал, мэдээлэлтэй нь холбогдуулж Байнгын хорооны гишүүд асуулт тавьж, хариулт авч болно.

$22^1$.5.Нээлттэй сонсох үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг Байнгын хороо, Тамгын газар хариуцна."

18/ 23.3.2-ын 2 дахь өгүүлбэр:

"Санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч болно."

19/ 23.4-ийн 3 дахь өгүүлбэр:

"Чуулганаар хэлэлцэхээр тогтсон төсөл гэдгийг тухайн ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгасан асуудлыг ойлгоно."

20/ 23.7-ийн "а" заалтын 2 дахь өгүүлбэр:

"Энэ тохиолдолд санал хураалт явуулахгүй бөгөөд зохих Байнгын хороонд шилжүүлж байгааг зарлана;"

21/ 23.12.3-ын "г" заалт:

"г/ энэ дэгийн 22.11-д заасан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг зохих Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж, анхны хэлэлцүүлгээр батална. Зохих Байнгын хорооны санал дэмжигдээгүй бол уг асуудлаарх анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн Байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналаар энэ дэгийн 23.12.3-ын "в"-д заасан үндэслэлээр дахин санал хурааж шийдвэрлэнэ."

Хоёр."Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн 1.1-ийн "хуралдааны" гэсний өмнө "чуулганы"; 15.5-ын "дүгнэлтийг" гэсний дараа "Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний эзгүйд орлож байгаа цэцийн аль нэг гишүүн танилцуулж,"; 20.2-ын "Хоёр дахь хэлэлцүүлгээр" гэсэн хэсгийн 3 дахь өгүүлбэрийн "Төсвийн зарлагын" гэсний дараа "хяналтын" гэж тус тус нэмсүгэй.

Гурав."Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 1.6 дахь заалт:

"1.6.Улсын Их Хурлын өглөөний нэгдсэн хуралдаан 9.00 цагаас, үдээс хойшхи нэгдсэн хуралдаан 15.00 цагаас эхэлнэ."

2/ 1.8 дахь заалт:

"1.8.Улсын Их Хурал долоо хоног бүрийн Баасан гаригийн 15.00 цагаас Засгийн газрын мэдээлэл, Засгийн газарт тавьсан асуулгын хариуг сонсоно."

3/ 7.2 дахь заалтын 2 дахь өгүүлбэр:

"Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдохоор нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурал санал хураахгүй бөгөөд асуулт тавьж, хариулт авч болно.

4/ 12.2 дахь заалт:

"12.2.Ерөнхийлөгч ажлын тайлангаа жил бүр Улсын Их Хуралд ирүүлж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсгоно. Тайлантай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж болно."

5/ 14.3 дахь заалт:

"14.3.Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг 14 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж, энэ талаар тогтоол батална.

6/ 15.1 дэх заалт:

"15.1.Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлаар Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг хэлэлцэхэд дараахь журмыг баримтална:"

7/ 19.3 дахь заалт:

"19.3.Улсын Их Хурлын гишүүн асуултын хариуг бичгээр авсны дараагаар уг хариуг Байнгын хорооны хуралдаанд сонсох эсэх, хэзээ сонсох тухай саналаа Байнгын хорооны даргад бичгээр ирүүлнэ. Асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанд сонсох өдөр, цагийг Байнгын хорооны дарга шийдвэрлэнэ."

8/ 19.5 дахь заалт:

"19.5.Асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүнээс бусад гишүүн хуралдаан даргалагчийн зөвшөөрсний дагуу асуултын хариутай холбогдуулж тухайн асуултын сэдвээр Засгийн газрын гишүүн болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын холбогдох албан тушаалтанд тодруулан асуулт тавьж болно."

9/ 19.7 дахь заалт:

"19.7.Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, нам, эвслийн бүлэг асуулгынхаа хариуг бичгээр авсны дараа уг хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсох эсэх, хэзээ сонсох тухай саналаа Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлнэ. Асуулгын хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар сонсох өдөр, цагийг Улсын Их Хурлын дарга шийдвэрлэнэ."

10/ 19.8-ын 3 дахь өгүүлбэр:

"Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гадна Улсын Их Хурлын бусад гишүүн хуралдаан даргалагчийн зөвшөөрснийг дагуу асуулгын хариутай холбогдуулж тухайн асуулгын сэдвээр Засгийн газрын гишүүн болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын холбогдох албан тушаалтанд тодруулан асуулт тавьж болно."

11/ 20.2-ын "Хоёр дахь хэлэлцүүлгээр" гэсэн хэсгийн 5 дахь өгүүлбэр:

"Гаргасан саналаар энэ дэгийн 23.5-д заасан журмын дагуу санал хураалт явуулж, улсын төсвийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр зохих Байнгын хороонд шилжүүлнэ."

12/ 21.2 дахь заалт:

"21.2.Төслийн цар хүрээ, боловсруулах ажлын хэмжээ, шаардлагыг харгалзан Байнгын хороогоор хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэх, эсхүл анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Ажлын хэсгийн гишүүдийн зонхилох хувь нь Улсын Их Хурлын гишүүд байна.

Ажлын хэсэг нь дараахь чиг үүрэгтэйгээр ажиллана:

1/хуралдаанаараа тухайн төслийг хэлэлцэн, үзэл баримтлалын чанартай асуудлыг нарийвчлан тодруулах үүднээс холбогдох байгууллагаас мэдээлэл, судалгаа гаргуулан авах, дүн шинжилгээ хийх;

3/тухайн асуудлаар санал, дүгнэлт боловсруулж зохих Байнгын хорооны хуралдаанд оруулах."

Улсын Их Хурлын чуулганаар тухайн асуудлыг хэлэлцэхэд түүнийг хариуцаж байгаа Байнгын хороо, Тамгын газрын ажилтнууд оролцоно. Мэдээлэл авах үүднээс Монгол Улсын сайд, дэд сайд, газар, хэлтсийн дарга, холбогдох бусад хүмүүсийг байлцуулж болно.

13/ 21.3 дахь заалт:

"21.3.Хууль санаачлагч нь хэлэлцүүлгийн аль ч шатанд төслөө татан авч болно. Энэ тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлнэ. Уг хүсэлтийг хуралдаан даргалагч Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд албан ёсоор танилцуулснаар төслөө татан авсанд тооцно."

14/ 22.7-ийн 3 дахь өгүүлбэр:

"Байнгын хороо зарчмын зөрүүтэй санал гаргаагүй, гишүүд санал нэгдсэн тохиолдолд төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн дүгнэлтээ анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн дүгнэлттэй хамтатган гаргаж болно."

15/ 22.11 дэх заалт:

"22.11.Төслийн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуулийн заалттай зөрчилдвөл Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь хэлэлцүүлж болно. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай бол холбогдох Байнгын хороогоор заавал хэлэлцүүлнэ. Төслийг холбогдох Байнгын хороо хэлэлцэж, санал, дүгнэлтээ зохих Байнгын хорооны танилцуулгад тусгуулах буюу, эсхүл Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна."

16/ 23.12.5-ын 3 дахь өгүүлбэр:

"Хэрэв төслийг бүхэлд нь батлах саналыг гишүүдийн олонхи дэмжээгүй бол уг төслийг хууль санаачлагчид нь буцаах тогтоол батална."

Дөрөв. "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн 1.9-ийн "гишүүдийн олонхийн" гэснийг "Улсын Их Хурлын дарга, Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн"; "Хорь"-ийн гарчигийн, 20.1-20.3 дахь заалтын "төвлөрсөн төсөв" гэснийг "төсөв"; 20.2-ын "ерөнхийлөн захирагчид" гэснийг "ерөнхийлөн захирагчдыг"; 15.3-ын "15.2-т" гэснийг "15.3-т"; "14.6" гэсэн дугаарыг "14.5"; "15.2, 15.3, 15.4, 15.5, 15.6, 15.7" гэсэн дугаарыг "15.3, 15.4, 15.5, 15.6, 15.7, 15.8"; 23.5.4-ийн "Тамгын газар" гэснийг "Байнгын хороо"; 23.7-ийн эхний өгүүлбэрийн "санал хураах шийдвэрлэнэ." гэснийг "гаргана." гэж тус тус өөрчилсүгэй.

Тав. "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн 1.11.8-ын "шийдвэрлэх", 19.2-ын "амаар болон" гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Зургаа. "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн 14.5 дахь заалт, 20.2-ын "нэг дэх хэлэлцүүлгээр" гэсэн хэсгийн "төвлөрүүлэн захирагчдыг" гэснийг, мөн 26.6 дахь заалтыг тус тус хассугай.

Долоо. Энэ тогтоолыг 2004 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 83 | Улаанбаатар хот

### Цэргийн дүрэмт хувцасны зарим загварыг батлах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Зэвсэгт хүчний офицер, ахлагч, Нэгдсэн Үндэсний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багийн бие бүрэлдэхүүний дугуй малгай болон нарнаас хамгаалах бүрх малгайн загварыг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 180 дугаар зарлигаар батлагдсан "Цэргийн албан хаагчдын дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварын нэр, код" –ын төсгөлд "26. Дугуй малгай /загварын код/ 1-16" , "27. Нарнаас хамгаалах, өнгөлөн далдлалтын бүрх малгай / загварын код / 1-17" гэсэн нэмэлт оруулсугай.

3. "Цэргийн хувцасны загварыг батлах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан 27, 36, 43, 47, 53, 56, 61, 66, 71, 77, 82, 91, 95, 103, 112, 117, 123, 127, 133, 136, 146, 150, 154, 190б, 199, 200, 204а, 225, 230, 235, 260, 261, 267, 279, 329, 334, 346 дугаар загварыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 05 дугаар сарын 20-ныөдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

## Дугуй малгай



Загварын код 1-16

## НАРНААС ХАМГААЛАХ, ӨНГӨЛӨН ДАЛДЛАЛТЫН БҮРХ МАЛГАЙ



Загварын код 1-17

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 5 дугаар сарын 21-ний өдөр** | **Дугаар 86** | **Улаанбаатар хот**

**Удо Хаазег "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, монгол орныг өөрийн оронд сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ХБНГУ-ын Дааме Шпревальд мужийн Шөнефельд дүүргийн Засаг захиргааны дарга Удо Хаазег "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр** | **Дугаар 84** | **Улаанбаатар хот**

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр 1 дүгээр хавсралт, улсын төсвийн болон замын сангийн хөрөнгөөр 2004 онд хэрэгжүүлэх зам, гүүрийн барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Шинээр эхлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь батлагдсаны дараа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, барилга байгууламж, төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн явц, ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг үндэслэн энэ тогтоолоор батлагдсан хөрөнгийн дүнд нь багтаан шаардлагатай бол зохицуулалт хийж ажиллахыг Сангийн, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН**

***Засгийн газрын 2004 оны 84 дүгээр тогтоолын 1-р хавсралт***

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2004 оны жагсаалт (Төсвийн эрх захирагчаар)**

(сая төг)

| д.д | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал | Эхлэх, дуусах хугацаа | Төсөвт өртөг | Үүнээс 2004 онд санхүүжих |
|---|---|---|---|---|
| А | Б | 1 | 2 | 3 |
| I | **Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** | | **350.0** | **350.0** |
| 1 | УИХ-ын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад орон сууц худалдан авах, Улаанбаатар | 2002-2004 | 250.0 | 250.0 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| II | **Монгол Улсын Ерөнхий сайд** | | **635.5** | **635.5** |
| II.1 | Тагнуулын ерөнхий газар | | 191.8 | 191.8 |
| 1 | Конторын барилга, 12 хүн, 2 машины гараащ, Говь-Алтай | 2004-2004 | 65.0 | 65.0 |
| 2 | Их засвар | 2004-2004 | 26.8 | 26.8 |
| 3 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| II.2 | Төрийн тусгай хамгаалалтын газар | | 88.2 | 88.2 |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 88.2 | 88.2 |
| II.3 | Улсын мэргэжлийн хяналтын газар | | 100.0 | 100.0 |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| II.4 | "МОНЦАМЭ" агентлаг | | 30.0 | 30.0 |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 30.0 | 30.0 |
| II.5 | Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар | | 182.5 | 182.5 |
| 1 | Бүсийн төвд GPS станц суурилуулах | 2004-2004 | 117.5 | 117.5 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 65.0 | 65.0 |
| II.6.4 | Гамшгаас хамгаалах ерөнхий газар | | 43.0 | 43.0 |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 18.0 | 18.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| II.6.4 | Гамшгаас хамгаалах ерөнхий газар | | 43.0 | 43.0 |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 18.0 | 18.0 |
| 2 | Их засвар | 2004-2004 | 25.0 | 25.0 |
| III | **Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга** | | **2,698.5** | **1,227.0** |
| 1 | Төрийн мэдээллийн сүлжээний компьютер, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн шинэчлэлт | 2004-2005 | 287.8 | 100.0 |
| 2 | Сонсголгүйчүүдийн дотуур байр, 112 хүн, Улаанбаатар | 2004-2004 | 250.0 | 250.0 |
| 3 | Их засвар | 2003-2004 | 1,025.0 | 525.0 |
| 4 | Тоног төхөөрөмж | 2003-2004 | 320.0 | 150.0 |
| 5 | Аймгийн ЗДТГазрын контор, Улиастай | 2004-2005 | 783.7 | 170.0 |
| 6 | Сүмбэр сумын ЗДТГ-ын байрны өөрчлөлт, засвар | 2004-2004 | 32.0 | 32.0 |
| IY | **Гадаад хэргийн яам** | | **296.0** | **296.0** |
| 1 | Астана хотод ЭСЯ-нд байр худалдан авах | 2004-2004 | 40.0 | 40.0 |
| 2 | Их засвар | 2004-2004 | 143.0 | 143.0 |
| 3 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 113.0 | 113.0 |
| Y | **Сангийн яам** | | **3,943.0** | **2,127.0** |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 25.0 | 25.0 |
| 2 | Их засвар | 2004-2004 | 95.0 | 95.0 |
| Y.1 | Цагааннуурын боомтын АТХШНЦогцолбор, Баян-Өлгий | 2003-2004 | 2,550.0 | 1,434.0 |
| Y.2 | УТЕГазрын конторын өргөтгөл, Улаанбаатар | 2004-2006 | 800.0 | 100.0 |
| Y.3 | Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах | | 473.0 | 473.0 |
| YI | **Хууль зүй, дотоод хэргийн яам** | | **3,600.0** | **2,157.2** |
| YI.1 | Яамны дүн | | **71.0** | **71.0** |
| 2 | ХЗДХЯамны их засвар | 2004-2004 | 21.3 | 21.3 |
| 3 | ТТАХНЭмнэлгийн тоног төхөөрөмж | 2004-2004 | 27.0 | 27.0 |
| 4 | ХЗДХЯамны тоног төхөөрөмж | 2004-2004 | 22.7 | 22.7 |
| YI.2 | Цагдаагийн ерөнхий газар | | **748.0** | **648.0** |
| 1 | Эргүүл хамгаалалтын 801-р хорооны штаб сумангуудын байр | 2003-2004 | 400.0 | 300.0 |
| 2 | Цагдаагийн хэсгийн байр, 30 ш | 2004-2004 | 150.0 | 150.0 |
| 3 | Их засвар | 2004-2004 | 118.0 | 118.0 |
| 4 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 80.0 | 80.0 |
| YI.3 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | | **458.0** | **258.0** |
| 1 | Аймгуудад баривчлах байр, гадна хамгаалалтын хашаа барих | 2003-2004 | 223.0 | 113.0 |
| 2 | Херс хүүлэлтийн ажил | 2002-2004 | 130.0 | 40.0 |
| 3 | Баривчлах байр, эмэгтэйчүүдийн хорих | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| 4 | Баривчлах байр, 457-р анги, Ховд | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| 5 | Тоосгоны үйлдвэр, 4 сая ш. тоосго, 419-р анги, Хэнтий | 2004-2004 | 15.0 | 15.0 |
| 6 | Их засвар | 2004-2004 | 30.0 | 30.0 |
| 7 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| YI.4 | Хил хамгаалах ерөнхий газар | | **2,246.0** | **1,103.2** |
| 1 | Хилийн 27-р отряд Дорнод, Мэнэн | 1999-2004 | 676.7 | 137.4 |
| 2 | Хилийн 0129-р ангийн штаб, цэргийн байр, Дорноговь, Эрдэнэ сум | 2002-2005 | 735.0 | 250.0 |
| 3 | 0277, 0257-р ангиудын хилийн хэсэгт инженерийн байгууламж барих, Завхан, Хөвсгөл аймгийн хилийн хэсэгт | 2003-2004 | 156.0 | 100.0 |
| 4 | Хилийн 0166-р ангийн Замбилгэхийн застав, Говь-Алтай, Эрдэнэ сум | 2004-2004 | 158.8 | 158.8 |
| 5 | Хилийн модон шонг төмөр бетон шонгоор солих, Дорнод | 2004-2004 | 56.0 | 56.0 |
| 6 | 0166-р ангийн Чандаганы хилийн харуулд өрөмдмөл худаг /Өмнөговь/ | 2004-2004 | 12.0 | 12.0 |
| 7 | Хилийн отрядын соёлын төв, спорт заал, /Ховдын Үенч сум/ | 2004-2004 | 138.0 | 76.0 |
| 8 | 0214-р ангийн Өргөстэйн хилийн харуулд өрөмдмөл худаг Говь-Алтайн Алтай сум | 2004-2004 | 13.5 | 13.0 |
| 9 | Их засвар | 2004-2004 | 150.0 | 150.0 |
| 10 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 150.0 | 150.0 |
| YI.5 | Үндэсний архивын газар | | **77.0** | **77.0** |
| 1 | Үндэсний төв архивын барилгын их засвар | 2004-2004 | 30.0 | 30.0 |
| 2 | Галын болон хамгаалалтын дохиоллын систем, архивын баримт хадгалах нягтруулсан шүүгээ, тоног төхөөрөмж | 2004-2004 | 47.0 | 47.0 |
| YII | **Байгаль орчны яам** | | **100.0** | **100.0** |
| 1 | Цаг уурын станцын барилга барих, Төв | 2004-2004 | 5.0 | 5.0 |
| 2 | Цаг уурын станцын барилга барих, Дундговь | 2004-2004 | 5.0 | 5.0 |
| 3 | Цаг уурын станцын барилга барих, Завхан | 2004-2004 | 5.0 | 5.0 |
| 4 | Цаг уурын станцын барилга барих, Хэнтий | 2004-2004 | 5.0 | 5.0 |
| 5 | Байгаль орчны албанд байр худалдан авах, Ховд | 2004-2004 | 5.0 | 5.0 |
| 6 | Их засвар | 2004-2004 | 45.0 | 45.0 |
| 7 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 30.0 | 30.0 |
| YIII | **Батлан хамгаалахын яам** | | **606.0** | **482.0** |
| 1 | Зэвсгийн агуулах, 12х6м, 12ш, Дорнод, 327-р анги | 2004-2005 | 128.0 | 64.0 |
| 2 | Гэрээт цэргийн байр, Дорнод, 327-р анги | 2004-2005 | 110.0 | 50.0 |
| 3 | Цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэл, Улаанбаатар | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| 4 | Их засвар | 2004-2004 | 188.0 | 188.0 |
| 5 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 80.0 | 80.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| IX | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд | | 16,008.7 | 7,368.8 |
| 1 | Сургуулийн барилга, 928 суудал, Дорноговь, Сайншанд | 2002-2005 | 986.9 | 300.0 |
| 2 | Сургуулийн барилга, 960 суудал, Ховд, Жаргалант | 2003-2005 | 1,250.0 | 400.0 |
| 3 | Сургуулийн өргөтгөл, 320 суудал, Увс, Өмнөговь | 2003-2004 | 288.2 | 255.2 |
| 4 | Сургуулийн барилга, 240 суудал, Өмнөговь Мандал | 2003-2004 | 205.0 | 175.0 |
| 5 | Сургуулийн барилга, 240 суудал, Хэнтий, Баянхутаг | 2003-2004 | 240.0 | 190.0 |
| 6 | Сургуулийн биеийн тамирын заал, 15х30 м, Говь-Алтай, Тонхил | 2004-2005 | 160.0 | 45.0 |
| 7 | Сургуулийн өргөтгөл, 320 суудал, Архангайн Хайрхан | 2003-2004 | 346.0 | 296.0 |
| 8 | Сургуулийн өргөтгөл, 640 суудал, Дорнод, Хэрлэн | 2004-2005 | 510.0 | 40.0 |
| 9 | Сургуулийн барилга, 640 суудал, Баянхонгор | 2004-2006 | 765.0 | 50.0 |
| 10 | Сургуулийн барилга, 640 суудал, Өвөрхангай, Арвайхээр | 2004-2005 | 380.0 | 80.0 |
| 11 | Сургуулийн өргөтгөл, 640 суудал, Хөвсгөл, Мөрөн | 2004-2005 | 490.0 | 100.0 |
| 12 | СУИСургуулийн хичээлийн байрны дуусгал, 704 суудал, УБ | 2004-2005 | 510.0 | 120.0 |
| 13 | Сургууль, 640 суудал, Улаанбаатар, СХД | 2004-2005 | 620.0 | 40.0 |
| 14 | Дотуур байрны дуусгал, Хөвсгөл, Улаан-Уул | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| 15 | Сургуулийн өргөтгөл, 240 суудал, Булган, Рашаант | 2003-2004 | 277.5 | 177.5 |
| 16 | Сургуулийн дотуур байр, 65 ор, Төв, Баян-Өнжүүл | 2003-2004 | 189.7 | 129.7 |
| 17 | Цэцэрлэг, 50 ор, Архангай, Цэнхэр | 2004-2004 | 56.0 | 56.0 |
| 18 | Цэцэрлэгийн дуусгал, Дундговь, Дэлгэрхангай | 2003-2004 | 108.0 | 28.0 |
| 19 | Цэцэрлэг, 240 ор, Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг | 2004-2005 | 245.0 | 45.0 |
| 20 | Цэцэрлэг, 100 ор, Өвөрхангай, Уянга | 2004-2005 | 173.0 | 73.0 |
| 21 | Сургуулийн спорт заал, Булган, Баян-Агт | 2004-2005 | 128.0 | 20.0 |
| 22 | 10 жилийн 2-р сургууль, 240 суудал, Улиастай | 2004-2005 | 230.0 | 40.0 |
| 23 | Сургуулийн өргөтгөл, 240 суудал, Сүхбаатар, Эрдэнэцагаан | 2004-2005 | 220.0 | 40.0 |
| 24 | Соёлын төвийн дуусгал, Ховд, Манхан | 2003-2004 | 180.0 | 110.0 |
| 25 | Цэцэрлэг, Соёлын төвийн дуусгал, Дундговь, Дэрэн | 2003-2004 | 83.6 | 18.6 |
| 26 | Соёлын төвийн барилга, 150 суудал, Дорнод, Баян-Уул | 2003-2004 | 127.9 | 78.0 |
| 27 | Соёлын төвийн дуусгал, Булган, Сайхан | 2004-2005 | 96.0 | 30.0 |
| 28 | Соёлын төвийн барилга, Увс, Завхан сум | 2004-2005 | 140.0 | 30.0 |
| 29 | Соёлын төв. 150 суудал, Дундговь, Сайхан-Овоо | 2004-2005 | 140.0 | 30.0 |
| 30 | Соёлын төв. 200 суудал, Ховд, Дарви | 2004-2005 | 225.0 | 40.0 |
| 31 | Соёлын төвийн дуусгал, Сүхбаатар, Баруун-Урт сум | 2004-2004 | 150.0 | 150.0 |
| 32 | Соёлын төв. 150 суудал, Увс, Давст | 2004-2005 | 130.0 | 30.0 |
| 33 | Мэдээлэл технологийн үндэсний паркийн барилгын шинэчлэлт | 2004-2004 | 30.0 | 30.0 |
| 34 | АХБ-ны "БСХХ-2" төслийн Монголын талын хөрөнгө | 2003-2006 | 2,080.0 | 600.0 |
| 35 | Жайка-гаар хэрэгжих төслийн дотоод эх үүсвэр | 2003-2007 | 216.0 | 38.0 |
| 36 | Япон улсын ЗГ-ын тусламжаар "Сургуулийн барилгын өргөтгөл-2" төслийн дотоод эх үүсвэр, Дархан, Орхон | 2004-2005 | 350.0 | 204.0 |
| 37 | Сургуулийн биеийн тамирын заалны дуусгал, Говь-Алтай, Хөхморьт | 2004-2004 | 90.0 | 50.0 |
| 38 | Сургуулийн барилга, 320 суудал, Сэлэнгэ, Мандал | 2004-2005 | 440.0 | 43.9 |
| 39 | Их засвар | 2004-2004 | 427.5 | 427.5 |
| 40 | Соёлын төвийн барилгын их засварт нэмж олгох хөрөнгө | 2004-2004 | 336.4 | 336.4 |
| 41 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 500.0 | 500.0 |
| 42 | Сургууль, соёлын байгууллагын их засвар | 2004-2004 | 1900 | 1900 |
| X | Дэд бүтцийн сайд | | 159,455.4 | 31,885.2 |
| I.1 | **Эрчим хүч** | | **86,610.1** | **12,186.8** |
| X.1.1 | **Дулааны цахилгаан станц, дулааны шугам** | | **19,664.2** | **1,203.0** |
| 1 | Улаанбаатар хотын дулааны үр ашгийн төслийн зээлийн дотоод эх үүсвэр | 1998-2006 | 6,606.0 | 110.2 |
| 2 | Дулааны гадна шугам, ф-1000 мм, 6.1 км, (ТЭЦ 3- ТЭЦ 4 станцуудын хооронд), Улаанбаатар | 2002-2004 | 3,344.9 | 300.0 |
| 3 | Дулааны 4-р цахилгаан станцын 2-р шатны шинэчлэлтийн Монголын талын хөрөнгө | 2004-2006 | 8,917.0 | 400.0 |
| 4 | Дулааны шугамын шинэчлэлт Увс, Улаангом | 2003-2004 | 218.3 | 172.8 |
| 5 | Дулааны станцын КЕ 25-14 С зуухны шинэчлэлт, Баян-Өлгий | 2004-2005 | 196.0 | 70 |
| 6 | Дулааны станцын шинэчлэлт, Сэлэнгэ | 2004-2005 | 380.0 | 150 |
| X.1.2 | **6, 10, 15, 35, 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө:** | | **29,742.4** | **6,518.8** |
| 1 | Дөргөний УЦС-Мөнхдэд сумын 110 кВ-ын ЦДАШ, 76 км, дэд өртөө, 2х10 мВа. Ховд | 2002-2006 | 2,320.0 | 50.0 |
| 2 | Тайширын УЦС-Улиастай 110 кВ-ын ЦДАШ, 135 км, дэд өртөө 1х1; 1х10 мВа, Завхан | 2004-2006 | 4,300.0 | 100.0 |
| 3 | Тайширын УЦС-Алтайн 35 кВ-ын ЦДАШ, 47 км, дэд өртөө, 1х1 мВа, Говь-Алтай | 2003-2004 | 972.8 | 594.3 |
| 4 | Тариат-Жаргалант сумын 35 кВ-ын ЦДАШ, 86.6 км, дэд өртөө, 1х1 мВт. Хөвсгөл | 2003-2004 | 650.0 | 550.0 |
| 5 | Зуунтал-Галшар сумын 35 кВ-ын ЦДАШ, 61 км, дэд өртөө, 1х1 мВа. Хэнтий | 2003-2004 | 915.0 | 715.0 |
| 6 | Батноров-Баян-Адарга сумын 35 кВ-ын ЦДАШ, 80 км, дэд өртөө, 1х1 мВа. Хэнтий | 2003-2005 | 1,057.0 | 400.0 |
| 7 | Тэгрэг-Гучин-Ус сумын 10 кВ-ын ЦДАШ, 50 км, дэд өртөө, 1х0.4 мВа. Өвөрхангай | 2004-2005 | 400.0 | 200.0 |
| 8 | Баян-Адарга-Биндэр сумын 15 кВ-ын ЦДАШ, 47 км, дэд өртөө, 1х0.1; 1х 0.16 мВа, Хэнтий | 2004-2005 | 423.0 | 141.0 |
| 9 | Тарагт - Хайрхандулаан сумын 10 кВ-ын ЦДАШ, 54 км, дэд өртөө, 1х0.4 мВа. Өвөрхангай | 2003-2004 | 250.7 | 81.6 |
| 10 | Уулбаян-Түвшинширээ сумын 10 кВ-ын ЦДАШ 56 км, дэд өртөө, 1х0.1; 1х0.16 мВа. Сүхбаатар | 2004-2005 | 448.0 | 100.0 |
| 11 | Төвшийн говь-Адаацаг сумын 15 кВ-ын ЦДАШ, 64 км, дэд өртөө, 1х0.1; 1х0.16 мВа. Дундговь | 2003-2004 | 492.5 | 317.0 |
| 12 | Галшар-Дэлгэрэх сумын 10 кВ-ын ЦДАШ, 58.3 км, дэд өртөө, 1х0.1; 1х0.16 мВа. Хэнтий | 2004-2005 | 467.0 | 100.0 |
| 13 | Сайншанд-Сайхандулаан сумын 35 кВ-ын ЦДАШ, 91 км, дэд өртөө, 1х0.4 мВа. Дорноговь | 2004-2005 | 1,092.0 | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12 | Сумын хүн эмнэлгийн барилга, 10 ор, Сэлэнгэ, Хушаат | 2004-2004 | 110.0 | 110.0 |
| 13 | Эмнэлгийн засвар шинэчлэлт, Багахангай | 2004-2004 | 80.0 | 80.0 |
| 14 | Хүүхдийн эмнэлэг, Завхан аймаг | 2004-2006 | 300.0 | 100.0 |
| 15 | "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-2"-ийн Монголын талын хөрөнгө | 2003-2008 | 2,431.0 | 287.0 |
| 16 | Өрхийн эмнэлгийн барилга, Улаанбаатар ** | 2004-2004 | 150.0 | 150.0 |
| 17 | Их засвар | 2004-2004 | 400.0 | 400.0 |
| 18 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 400.0 | 400.0 |
| 19 | Хот, хөдөөгийн хүн эмнэлгийн барилгын их засвар | 2004-2004 | 1100 | 1100 |
| XY | **Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч** | | **20.0** | **20.0** |
| 1 | Их засвар | 2004-2004 | 6.0 | 6.0 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 14.0 | 14.0 |
| XYI | **Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга** | | **55.0** | **55.0** |
| 1 | Их засвар | 2004-2004 | 30.0 | 30.0 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 25.0 | 25.0 |
| XYII | **Улсын Ерөнхий прокурор** | | **26.5** | **26.5** |
| 1 | Их засвар | 2004-2004 | 26.5 | 26.5 |
| XYIII | **Үндэсний статистикийн газар** | | **40.0** | **40.0** |
| 1 | Интернетийн сүлжээнд холбох | | 20.0 | 20.0 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 20.0 | 20.0 |
| XIX | **ЦАУЗБУКомиссын дарга** | | **110.0** | **110.0** |
| 1 | Хэлмэгдсэн иргэдэд олгох орон сууц | 2004-2004 | 100.0 | 100.0 |
| 2 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 10.0 | 10.0 |
| XX | **Үндсэн хуулийн цэцийн дарга** | | **5.0** | **5.0** |
| 1 | Тоног төхөөрөмж | 2004-2004 | 5.0 | 5.0 |
| | **Нийт хөрөнгө оруулалтын дүн** | | **198,027.5** | **52,560.0** |

Тайлбар ** Нийслэлийн засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчидтай гэрээ байгуулан хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

*Засгийн газрын 2004 оны 84 дүгээр тогтоолын 2-р хавсралт*

## Улсын төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2004 оны жагсаалт

| д.д | Төсөл арга хэмжээний нэр, байршил | Хүчин чадал | Барих хугацаа | Төсөвт өртөг | 2004 оны төсөл: Бүгд | Үүнээс: Төсөв | Үүнээс: Замын сан | Ашиглалтад оруулах хугацаа: Хүчин чадал | Ашиглалтад оруулах хугацаа: Хугацаа (улирал) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | Нэг. Гадаадын зээлээр хэрэгжиж буй төслүүдийн дотоод эх үүсвэр | | | 21,499.4 | 5,887.3 | 4,722.3 | 1,165.0 | | |
| | а. ТЭЗҮ, хайгуул, зураг төсөв | | | 1,346.9 | 607.1 | 607.1 | 0 | | |
| 1 | Чойр - Замын -Үүдийн хатуу хучилттай зам | | 2003-2004 | 1,000.0 | 300 | 300 | | | |
| 2 | Эрдэнэсант-Улаанбаатарын хатуу хучилттай замын засвар, шинэчлэлт | | 2004-2004 | 346.9 | 307.1 | 307.1 | | | |
| | Зам | | | 18,822.5 | 5,148.3 | 4,115.2 | 1,033.1 | | |
| | в. шинээр эхлэх | | | 5,310.1 | 978.5 | 531.2 | 447.3 | | |
| 1 | Эрдэнэт-Булган-Уньтын хатуу хучилттай зам | 146.2 км | 2002-2007 | 5,310.1 | 978.5 | 531.2 | 447.3 | | |
| | б шилжих | | | 13,512.4 | 4,169.8 | 3,584.0 | 585.8 | | |
| 1 | Налайх-Чойрын хатуу хучилттай зам | 200 км | 2000-2005 | 9,316.0 | 3,584.0 | 3,584.0 | | 200 км | IY |
| 2 | Арвайхээр-Эрдэнэсантийн замын засвар, шинэчлэлт | 215 км | 2001-2004 | 2,148.90 | 154.4 | | 154.4 | | |
| 3 | Арвайхээр -Ховдын сайжруулсан хайрган зам | 93 км | 2003-2005 | 953.4 | 414.1 | | 414.1 | 93 км | IY |
| 4 | Хархорин-Тосонцэнгэлийн сайжруулсан хайрган зам | 92.7 км | 2001-2004 | 1,094.10 | 17.3 | | 17.3 | | |
| | в.бусад | | | 1,330.00 | 131.9 | 0 | 131.9 | | |
| 5 | Тээврийг хөгжүүлэх төслийн барилгын хяналт, сургалт, тоног төхөөрөмж | | 2001-2005 | 1,330.00 | 131.9- | | 131.9 | | |
| | Хоёр. Замын сүлжээний засвар, арчлалт, замын хуулийг хэрэгжүүлэх | | 2004-2004 | 5,000.00 | 5,000.00 | | 5,000.00 | | |
| | Гурав. ЗГҮАМХ-т тусгагдсан зам, гүүр | | | 18,620.3 | 2,664.2 | 1,633.2 | 1,031.0 | | |
| | Зам | | | 16,898.5 | 1,633.2 | 1,633.2 | 0.0 | | |
| 1 | Улаангом-Хандгайтийн хатуу хучилттай зам | 58 км | 2003-2007 | 5,000.00 | 500 | 500 | | | |
| 2 | Ховдын Булган-Ярантын хатуу хучилттай зам | 65 км | 2002-2005 | 2,928.50 | 633.2 | 633.2 | | | |
| 3 | Өлгий-Цагааннуурын хатуу хучилттай зам | 69 км | 2004-2006 | 8,970.00 | 500 | 500 | | | |
| | Гүүр | | | 1,721.8 | 1,031.0 | 0.0 | 1,031.0 | | |
| 1 | Хөмүүлтийн модон гүүр, Хэнтий | 200 у/м | 2003-2004 | 350 | 115 | | 115 | 200 у/м | IY |
| 2 | Харнуурын төмөр бетон гүүр, Баян-Өлгий | 72 у/м | 2003-2004 | 256 | 156 | | 156 | 72 у/м | III |
| 3 | Зүүн бүрэнгийн төмөр бетон гүүр, Сэлэнгэ | 168 у/м | 2001-2004 | 435.8 | 400 | | 400 | 168 у/м | II |
| 4 | Буянтын төмөр бетон гүүр, Завхан | 170 у/м | 2002-2004 | 680 | 360 | | 360 | 170 у/м | IY |
| | Дөрөв . Мянганы замын төсөл | | | 22,126.6 | 3,996.0 | 3,996.0 | 0 | | |
| | Зам | | | 19,500.0 | 2,900.0 | 2,900.0 | 0 | | |
| 1 | Багануур -Өндөрхааны хатуу хучилттай зам | 200 км | 2004-2008 | 19,500.0 | 2,900.0 | 2,900.0 | | | |
| | Гүүр | | | 2,626.6 | 1,096.0 | 1,096.0 | 0 | | |
| 1 | Сархайрханы төмөр бетон гүүр, Завхан | 126.9 у/м | 2001-2004 | 1,658.00 | 800 | 800 | | 126.9 у/м | II |
| 2 | Шурагийн голын төмөр бетон гүүр, Ховд | 145.1 у/м | 2002-2004 | 968.6 | 296 | 296 | | 145.1 у/м | II |
| | НИЙТ ДҮН | | | 67,246.3 | 17,547.5 | 10,351.5 | 7,196.0 | | |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 85 | Улаанбаатар хот

**Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай**

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн $13^2$ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрмийг 1 дүгээр хавсралт, Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 16 дугаар хавсралт болгон тус тус батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

*Засгийн газрын 2004 оны 85 дугаар тогтоолын 1-р хавсралт*

## АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Архидан согтуурахтай тэмцэх сан (цаашид "Сан" гэх)-гийн зорилго нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, архидан согтуурсны улмаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учирч байгаа хор уршгийг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд оршино.

1.2. Сангийн үйл ажиллагааг Сангийн зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) удирдана.

1.3. Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

1.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

1.5. Зөвлөл хэлэлцсэн асуудлаа олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана. Тогтоолд Зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлнө.

1.6. Сангийн зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.7. Сангийн зөвлөлийн ажлын алба нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба байна.

1.8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.

1.9. Сангийн зөвлөл нь үйл ажиллагаагаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд жил бүр тайлагнана.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

2.1. Сангийн хөрөнгө Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн $13^2$.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн $13^2$.4-т заасныг үндэслэн дараахь үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газар санхүүжүүлж болно:

2.2.1. архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж оношлох, наркологийн тусламж үзүүлэх, хүн амыг эрүүлжүүлэх, эмчилгээний үр дүнг судлах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.2.2. архидан согтуурахаас сэргийлэх, архины хор уршгийг бууруулах талаар улсын хэмжээнд авч хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээ;

2.2.3. архидан согтуурснаас нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тогтоох судалгаа, шинжилгээний ажил.

2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба энэ дүрмийн 2.2-т заасан үйл ажиллагаа, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг төлөвлөж Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоосон журмын дагуу Засгийн газарт оруулна.

Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

3.1. Сангийн хөрөнгийг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн $13^2$.6-д заасан зориулалтаар зарцуулна.

3.2. Сангийн хөрөнгийг энэ дүрмийн 3.1-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Дөрөв. Сангийн зөвлөлийн бүрэн эрх

4.1. Сангийн зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

4.1.2. Сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргах;

4.1.3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг шалгаруулах;

4.1.4. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавих, үр дүнг шалгах, холбогдох мэдээ, тайланг хэлэлцэн үнэлэлт өгөх.

Тав. Сангийн өдөр тутмын үйл ажиллагаа зохион байгуулах

5.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг дараахь байдлаар зохицуулна:

5.1.1. Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

5.1.2. Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулахтай холбоотой бусад ажлыг зохицуулах;

5.1.3. Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах болон бусад үйл ажиллагаатай холбогдсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

***Засгийн газрын 2004 оны 138 дугаар тогтоолын 16-р хавсралт***

## АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Зөвлөлийн дарга | -Хууль зүй, дотоод хэргийн сайд; |
| Гишүүд: | -Санхүү, эдийн засгийн дэд сайд; |
| | -Эрүүл мэндийн дэд сайд; |
| | -Үйлдвэр, худалдааны дэд сайд; |
| | -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд; |
| | -Сэлэнгэ аймгийн Засаг дарга; |
| | -Цагдаагийн ерөнхий газрын дарга; |
| | -Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (тохиролцсоноор); |
| | -Улсын мэргэжлийн хяналтын газрын тэргүүн дэд дарга; |
| | -Нийслэлийн Засаг даргын орлогч; |
| | -Монголын үндэсний худалдаа,аж үйлдвэрийн танхимын тэргүүн (тохиролцсоноор); |
| | -Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (тохиролцсоноор); |
| | -"Улаанбаатар ротари клуб"-ийн ерөнхийлөгч (тохиролцсоноор); |
| | -Хүнс үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор); |
| | -Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор); |
| Нарийн бичгийн дарга | -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга. |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 86 | Улаанбаатар хот

**Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын Хоёрдугаар хэсгийн 4-ийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус салбарт гадаад орон, олон улсын байгууллагаас буцалтгүй тусламжаар олгосон бүтээгдэхүүний борлуулалтын сан, түүний хүүгийн орлогоос "Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан" байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Сангийн сайд Ч.Улаан нарт зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журмыг хавсралт ёсоор батлсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ**

*Засгийн газрын 2004 оны 86 дугаар тогтоолын хавсралт*

### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЖИЖИГ ҮЙЛДВЭРЛЭЛ-ШИНЭ ТЕХНОЛОГИ САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан (цаашид "сан" гэх)-г бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сан нь Засгийн газрын тусгай зориулалтын сангуудын бүрэлдэхүүн хэсэг болно.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хүнс, хөдөө аж ахуйн болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар батална.

2.2. Сангийн зөвлөл дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Төсөл, арга хэмжээний хэрэгжих боломж, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хүрэлцээ, удирдлагын болон мэргэжлийн боловсон хүчний чадавхи, зээлийг хугацаанд нь төлөх магадлал, барьцаалах эд хөрөнгө зэргийг хянан үзэж, төслийг сангийн зөвлөлийн хуралдаанаар нэгбүрчлэн хэлэлцэн шийдвэрлэх;

2.2.2. Төсөлд олгох зээлийн хэмжээ, эргэж төлөх хугацааг тогтоох;

2.2.3. Сангаас эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, зээлийг хугацаанд нь төлүүлэх ажлыг зохион байгуулах;

2.2.4. Сантай холбоотой, энэхүү журамд нийцсэн бүхий л асуудлыг сангийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх;

2.2.5. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээнд анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, үйл ажиллагааны тайланг улирал, жилээр гаргаж Сангийн, эдийн засгийн яаманд тушаах үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны сангийн асуудал хариуцсан нэгж (цаашид "Сангийн асуудал хариуцсан нэгж" гэх) хариуцан гүйцэтгэх бөгөөд түүний дүнтэй сангийн зөвлөл улирал бүр танилцаж байна.

2.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тэмдэглэл гаргана.

2.4. Сангийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн сайд тушаал гаргах бөгөөд энэ нь хөрөнгө зарцуулах эцсийн шийдвэр болно.

2.5. Сангийн зөвлөлийн хуралдааныг гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

2.6. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Хүнс, хөдөө аж ахуйн яамны сангийн асуудал хариуцсан нэгж эрхэлнэ.

Гурав. Сангийн санхүүгийн эх үүсвэр, зориулалт

3.1. Сангийн эх үүсвэр нь Хүнс, хөдөө аж ахуйн салбарт гадаад орон, олон улсын байгууллагаас буцалтгүй тусламжаар олгосон бүтээгдэхүүний борлуулалтын орлогын зарим хэсэг, түүний хүүгийн орлого, сангийн үйл ажиллагааны болон бусдад үйлчилгээ үзүүлснээс олсон орлого, тус санд оруулсан хөрөнгө болон зээлийн хураамж зэргээс бүрдэнэ.

3.2. Сангийн хөрөнгийн зориулалт нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх зорилготой хөтөлбөр, төсөлд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Дөрөв. Сангаас зээл олгоход баримтлах журам

4.1. Зээл хүсэгч нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

4.1.1. Төсөл;

4.1.2. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ, эсхүл төсөл хэрэгжүүлэгчийн иргэний үнэмлэхийн хуулбар, оршин суугаа хаяг;

4.1.3. Газар эзэмших гэрчилгээ;

4.1.4. Барьцаалах эд хөрөнгө /хувьцаа, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө/;

4.1.5. Банкны өр барагдуулах албаны тодорхойлолт;

4.1.6. Тухайн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, санхүүгийн талаархи харилцагч банкны тодорхойлолт;

4.1.7. Хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцэл.

4.2. Төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1. Төсөл нь сангийн зориулалтад нийцсэн, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлтэй жижиг үйлдвэрлэлийг эрчимжсэн технологиор явуулж, эдийн засгийн хувьд тогтвортой үр ашигтай ажиллах нөхцөлийг хангасан байх;

4.2.2. Төслийн цар хүрээ, давуу тал тодорхой байх;

4.2.3. Төслийн ямар арга хэмжээнд нь зориулж жижиг зээл авах, өөрийн хөрөнгө болон арилжааны банкны зээлээр ямар арга хэмжээг нь санхүүжүүлэхийг тодорхой заах, арилжааны банкнаас зээл авах талаар урьдчилан санал авсан байх;

4.2.4. Төслийг хэрэгжүүлэх явц, гарч болох эрсдэл, түүнийг шийдвэрлэх арга замын тухай үнэлгээ гаргасан байх;

4.2.5. Төсөл хэрэгжүүлэгчийн мэргэжил, ажил үүргийн хуваарийг заасан байх;

4.2.6. Зээлийг эргүүлэн төлөх санхүүгийн төлөвлөгөө хийгдсэн байхын дээр төсөл хэрэгжүүлэх газар, объектын талаар шаардлагатай материал, фото зураг хавсарган байна.

4.3. Зээл хүссэн аж ахуйн нэгж, иргэний өргөдөл, холбогдох баримт бичгийг Хүнс, хөдөө аж ахуйн яам хүлээн авна.

4.4. Хүнс, хөдөө аж ахуйн яамны холбогдох газар, хэлтсүүд төслийг бодлогын болон технологийн хувьд дэмжих боломжтой эсэх талаар дүгнэлт гаргаж, дэмжсэн төслөө Сангийн асуудал хариуцсан нэгжид үндэслэлийн хамт шилжүүлж, дэмжих боломжгүй төслийг эзэнд нь зохих тайлбарын хамт буцаана.

4.5. Бодлого болон технологийн хувьд дэмжигдсэн төсөл бүрийг Сангийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж зээл олгох эсэх талаар дүгнэлт гарган сайдад уламжилна.

Тав. Хөрөнгийг зарцуулах зарчим

5.1. Нэг төслийг зээлжүүлэх хөрөнгийн дээд хэмжээ нь 5.0 (таван) сая хүртэл төгрөг, зээлийг эргүүлэн төлөх хугацаа нь 2 хүртэл жил байна.

5.2. Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи төсөлд олгох зээл нь үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор жилийн 10.0 хувийн хураамжтай байна. Хугацаа хэтэрсэн зээлийн алдангийг арилжааны банкны жишгийг харгалзан тусгасан зээлдэгч, зээлдүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

5.3. Сангийн асуудал хариуцсан нэгж нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдын шийдвэрийг үндэслэн төслийн зээл олгох аж ахуйн нэгж, иргэнтэй зээлийн гэрээ байгуулж, зээлийг төслийн үе шат бүрт олгох, эргүүлэн төлүүлэх, зээлийн гэрээг дүгнэж Сангийн зөвлөлд танилцуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулна. Зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээг Сангийн асуудал хариуцсан нэгж аж ахуйн нэгж болон иргэн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

Зургаа. Бусад зүйл

6.1. Сангийн зөвлөлийн дүгнэлт, сайдын шийдвэргүйгээр аж ахуйн нэгж, иргэнд зээл олгохыг хориглоно.

6.2. Сангийн асуудал хариуцсан нэгж нь зээлдэгч аж ахуйн нэгж, иргэний гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн, төлбөрийн чадваргүй болсон, эд хөрөнгө эзэмших найдваргүй болсон тохиолдолд түүнтэй холбогдсон маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ. Маргаан шийдвэрлэхтэй холбогдон сангаас гаргасан зардлыг зээлдэгч аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр** **Дугаар 87** **Улаанбаатар хот**

**Хууль бусаар алт олборлож байгаа талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Говийн бага дархан цаазат газрын "Б" хэсэгт хууль бусаар алт олборлосон үйл ажиллагаанд дүгнэлт хийж улсын тусгай хамгаалалттай газар нутагт дахин зөрчил гаргуулахгүй байх талаар урьдчилан сэргийлэх, зөрчил илэрсэн тохиолдолд цаг алдалгүй таслан зогсоох, хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулах арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батбаатар нарт үүрэг болгосугай.

2. Тусгай хамгаалалттайгаас бусад алтны орд бүхий газарт хууль бусаар алт олборлож буй зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батбаатар, аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Уул уурхайн үйлдвэрлэлд хэрэглэж буй тэсэрч, дэлбэрэх бодис, холбогдох хэрэгслийн ашиглалт, хадгалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгасугай.

4. Хууль бусаар алт олборлосноос учирсан хохирлын хэмжээг тогтоож, холбогдох этгээдээр нөхөн төлүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээ авахыг Сангхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Байгаль орчны сайд У.Барсболд нарт үүрэг болгосугай.

5. Уул уурхайн орд, ашигт малтмалын нөөц бүхий бүс нутагт оршин сууж байгаа ард иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу ашигт малтмалын олборлолт явуулах талаар төр, засгийн бодлого, шийдвэрийг сурталчлах ажлыг эрчимжүүлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 2.5

☎ 329487